



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 1167

Шивээговь сум

**“Бохирын шугамын бөглөө гаргах, засварлах”
 ажлын гүйцэтгэлийг хүлээж авах комисс
 томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2022 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Бохирын шугамын бөглөө гаргах, засварлах”-ын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Гишүүд:

Д.Алтанцэцэг

(Илчлэг Шивээ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Ерөнхий инженер)

С.Солонго

(Илчлэг Шивээ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

ахуйн инженер)

Ч.Энхжаргал

(1 дүгээр багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Ц.Замбага

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг
төлөвлөлт, худалдаа авах ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Бохирын шугамын бөглөө гаргах, засварлах” ажлыг ашиглалтад оруулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг комиссын дарга (Ч.Сугармаа)-д, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Ц.Замбага), Илчлэг Шивээ Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч (В.Бурмаа) нарт, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, үр ашгийг дээшлүүлэн, ашиглалт хамгаалалтыг сайжруулахыг ашиглагч байгууллагын дарга (Ш.Чинболд) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ